

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БАТ-АМГАЛАН
НАРЫН 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 01 дүгээр сарын 17

№ 2023/05

Номгон

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрээний зорилго нь **Баянхонгор аймгийн Засаг даргаас Баянговь сумын Засаг даргын** хооронд үүсэх эрх, үүрэг, гүйцэтгэх ажил үйлчилгээ, түүний тоон болон чанарын үзүүлэлт, хүрэх үр дүн, төсвийн санхүүжилтийг тодорхойлох, гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тавигдах шаардлага, гэрээг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төсвийн тухай хуулийн 40 дүгээр заалтыг үндэслэн энэхүү гэрээг нэг талаас **Баянхонгор аймгийн Засаг дарга Долгорсүрэнгийн Мөнхсайхан** нөгөө талаас **Баянговь сумын Засаг дарга Батбаярын Бат-Амгалан** нар 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нэг жилийн хугацаатайгаар байгуулж, 2 хувь үйлдэв.

1.3.Уг гэрээнд аймгийн Засаг даргаас төлөөлөн гүйцэтгэх, сумын Засаг даргын чиг үүрэг, ажил үйлчилгээ түүний тоо хэмжээ, чанарт тавих шаардлага, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ түүний зардлын санхүүжилт, талуудын хүлээх үүрэг, гэрээний биелэлтийг тайлагнах, дүгнэх зэрэг гэрээний нөхцөлийг тусгав.

1.4.**Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын** хооронд байгуулсан гэрээтэй холбогдох харилцааг Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад салбарын үйл ажиллагааг зохицуулах болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.5. Хавсралт энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг

2.1.Төсвийн ерөнхийлөн захирагч болох аймгийн **Засаг дарга** дараах үүрэг хүлээнэ.

А.Тухайн сумд гүйцэтгэх ажлыг худалдаж авахад 514.973.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн санд 578.323.0 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгоно. /Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг

гүйцэтгэгчийг шалгаруулах тендерээр авсан үнийн дүнгийн хэмжээгээр санхүүжилт олгоно.

Б.Гэрээний нөхцөл болон ажил үйлчилгээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулах, дэмжлэг үзүүлэх, арга хэмжээг авч, харилцан уялдаатай ажиллах.

В.Сумын Засаг даргаас гүйцэтгэх үйл ажиллагааны үр дүнгийн талаарх эцсийн хариуцлагыг аймгийн Засаг дарга ажлаа тайлагнадаг дээд шатны байгууллага болох Засгийн газрын өмнө хариуцна.

Г.Санхүүжилтийн хуваарьт шаардлагатай тохиолдолд сар, улирлаар зохицуулалт хийж болно.

Гурав. Сумын Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Сумын Засаг дарга нь гэрээнд тусгагдсан арга хэмжээг тоо болон чанар, шалгуур үзүүлэлтийг хангаж, заалт бүрийг зорилтот түвшинд хүргэж хэрэгжүүлэхэд анхаарч, зохион байгуулалтыг шуурхай удирдлагаар хангаж, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тайлагнаж, аймгийн Засаг даргын өмнө хариуцах.

3.2.Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж, орлогыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг татаж, төсвийн сахилга батыг хянаж, зөрчилгүй ажилласан байх.

3.3.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын байрны дэг журам, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, ашиг сонирхол, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх.

3.4.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулж, аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах.

3.5 Аймаг орон нутагт хэрэгжиж байгаа дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлж, салбарын удирдлагуудтай нягт уялдаа холбоотой хамтран ажиллах.

3.6 Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх, төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх үнэлэх.

3.7.Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай зохион байгуулж, хяналт шинжилгээ үнэлгээний дүнг өмнөх оноос ахиулсан байх.

3.8.Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;

Дөрөв. Улсын төсвийн санхүүжилт

4.1.Сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилт нь төсөв батлах тухай, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан тухайн оны төсөв байх бөгөөд түүний санхүүжилтийг хуваарийн дагуу төрийн сангаар дамжуулан гүйцэтгэх.

4.2.Сумын төрийн сан төсөвт байгууллагын санхүүжилтийг төсвийн дансанд ажлын нэг хоногт багтаан шилжүүлэх.

4.3.Аймгийн Засаг даргын нэрийн өмнөөс сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилтийн төлбөрийг аймгийн Засаг даргатай тохиролцсон хуваарийн дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст шилжүүлнэ. Энэ тохиолдолд 4.2, 4.3 дахь заалт нэгэн адил хүчинтэй тооцох .

4.4.Төсвийн тухай хуулийн 41.1 , 41.2 дугаар зүйлд заасны дагуу сумын Засаг даргаас эрхлэн гаргасан сар бүрийн санхүүгийн тайлан, улирал бүрийн эцэст төсвийн хуваарилалт, зарцуулалт, бүрдүүлэлтэд хяналт тавьсан тайлан гаргаж аймгийн Засаг даргад хүргүүлэх.

4.5.Сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол аймгийн Засаг дарга түүний төлбөрийг хийх үүрэг хүлээхгүй. Ирүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний тайланд хийсэн үнэлгээгээр гэрээнд хийсэн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаагүй бол дараагийн улирал, жилийн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний төлбөрийг зохих журмын дагуу бууруулан зохицуулалт хийх.

4.6.Сумын санхүүгийн албаны дарга төрийн сангийн мэргэжилтэн болон төсвийн нягтлан бодогчдыг томилж чөлөөлөхдөө аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй зөвшилцөж Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөх.

4.7. Улс аймаг, сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, улс аймгийн төсвийн орлогод төвлөрүүлэх орлогыг цаг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх.

4.8. Сумын Засаг дарга нь төсөв болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлнэ.

Тав. Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээг дүгнэх

5.1. Гэрээний биелэлтийг хавсралтад заасан хэрэгжүүлэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшингийн үр дүнг журмын дагуу тайлагнах.

5.2. Сумын Засаг дарга гэрээний хэрэгжилтийг хагас жил 06 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнана.

5.3. Шаардлагатай бол тусгайлсан мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэнэ.

Зургаа . Гэрээгээр харилцан хүлээх үүрэг

6.1. Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ .

6.1.1. Төрийн албаны тухай, Төсвийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн заалтуудыг баримтлан ажиллана.

6.1.2. Гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж, хугацаа хожимдуулах тасалдуулах зэрэг алдаа дутагдал гаргахгүй ажиллах

6.1.3. Шаардлага гарсан нөхцөлд харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээг цуцалж болно.

Долоо. Маргааныг шийдвэрлэх

7.1. Гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэхдээ:

7.1.1. Хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээтэй холбогдон үүссэн асуудлыг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэж байна.

7.1.2. Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зохицуулах арга хэмжээ авхуулна.

7.1.3. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зөвлөгөө авч ажиллана.

Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

8.1.Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.2.Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь хийж, талууд гарын үсэг зурж гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг хадгална.

8.3.Гэрээнд тусгагдаагүй чиг үүрэг, ажил үйлчилгээг талууд харилцан зөвшилцөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх болно.

Ес. Гэрээний хариуцлага

9.1.Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгавар, хариутай албан бичиг, мэдээ тайланг хугацаанд нь шаардлагын дагуу гаргаж ирүүлнэ.

9.2.Сумын Засаг дарга гэрээний хавсралтад тусгагдсан үүргийг хангалттай биелүүлсэн тохиолдолд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага, урамшууллыг олгох эсэхийг шийдвэрлэнэ.



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.МӨНХСАЙХАН

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН



БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТ-АМГАЛАН

2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай 2023 онд
хамтран ажиллах гэрээний хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ,
АРГА ХЭМЖЭЭ

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/	2023 онд хүрэх түвшин
1	2	3	4
Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд			
1	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг irgen.bayanhongor.gov.mn цахим системээр авч, төрийн үйлчилгээг сайжруулах	Чанар: Судалгааны дүн, хамруулсан иргэдийн тоо Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр сахилга хариуцлагыг төрийн сайжруулж үйлчилгээг шуурхай болгосон байна.
2	Сумын төрийн байгууллагуудын дотоод, гадаад үйл ажиллагааг хяналт, удирдлагын нэгдсэн "ERP" системээр явуулж, мэргэжилтэн ажилтан бүр ашиглалтыг сайжруулах, удирдлага хяналт тавих	Тоо: Байгууллагын дотоод удирдлагын ERP систем ашиглаж хэвшсэн албан хаагчдын тоо Чанар: Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн албан бичиг, хүний нөөц, QR код бүхий цаг бүртгэлийн модулиудын ашиглалтыг 100 хувьд, бусад модулийг 80-аас багагүй хувьд хүргэх, Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	"ERP" систем ашиглан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэн ашиглаж хэвшсэн байна.
3	Албан бичиг төлөвлөлтийн eoffice.bayanhongor.gov.mn цахим системийг бүрэн цаасгүй технологи нэвтрүүлсэн байх	Тоо: eoffice.bayanhongor.gov.mn цахим систем ашиглаж хэвшсэн төрийн албан хаагчдын тоо Чанар: Иргэдийн өргөдөл, гомдлыг системээр шийдвэрлэж хэвшсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	eoffice.bayanhongor.gov.mn системийг бүрэн ашиглаж бичгийн цаас, принтерийн хорны зардлыг 30-аас багагүй хувиар хэмнэж, төрийн үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.
4	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлт, eoffice.bayanhongor.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулах, хяналт тавих	Тоо: Цахимаар хүлээн авсан өргөдлийн тоо Чанар: Иргэдээс хүлээн авсан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 85-аас дээш хувьд хүргэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.

1	2	3	4
5	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн операторын үйлчилгээг эрчимжүүлж иргэдэд таниулах, сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулах	Тоо: Сард 80-аас багагүй лавлагааг гаргасан байх Чанар: Төрийн үйлчилгээний чирэгдэл буурсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Шинээр нэвтрэх үйлчилгээг тухай бүрд иргэдэд хүргэж, чанар хүртээмжийг сайжруулсан байна.
6	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Чанар: Тайлангийн ирцийг 100 хувьд хүргэх Хугацаа: Цахим сангийн заасан хугацаанд тайлагнах	Тайлангийн хугацаа хоцрох зөрчил бүрэн арилж, чанарыг 70 хувьд дээш хувьд хүргэсэн байна.
7	Сумдын албан ёсны цахим хуудасны ашиглалтыг нэмэгдүүлж, өдөр тутмын мэдээ мэдээллийг нийтэлж сумын "Ил тод байдал"-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах	Тоо: 7 хоног, сар, улиралд нийтэлсэн мэдээний тоог Чанар: Төрийн байгууллагуудын ил тод байдлын шалгуур үзүүлэлт хангагдаж, иргэд цахимаар мэдээлэл авч хэвшсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.
8	Байгууллагуудын интернет сүлжээний хурдыг нэмэгдүүлж, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, мэргэжилтэн ажилтнуудын мэдлэгийг сайжруулах	Тоо: Мэдээллийн технологийн сургалтад хамруулсан ажилтан, мэргэжилтнүүдийн тоо Чанар: Байгууллагуудын интернетийн урсгалын хурдыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Цахим шилжилт, цахим засаглалын хүрээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд техникийн болон хүний нөөцийн мэдлэг, ажиллах нөхцөл сайжирсан байна.
9	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх	Чанар: Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, суралцах боломжийг бүрдүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Албан хаагчдын ажиллах нөхцөл, сурч хөгжих боломж бүрдэж, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.
10	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулан ажиллах	Тоо: Албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах 1-2 онцлог арга хэмжээ зохион байгуулах Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийн тоо Гэмт хэрэг зөрчилд холбогдсон албан хаагчийн тоо Чанар: төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүй	Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн ажилласан байна.

1	2	3	4
		сайжирсан байна. Хугацаа: Журмын хугацаагаар тайлагнах	
11	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохион байгуулж, төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх	Тоо: Зөрчилтэй томилгоо хийхгүй байх Чанар: Төрийн албаны стандартын хэрэгжилт, үр дүнг сайжруулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.
12	Гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ харьяалах нутгийн захиргааны байгууллагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу чанартай зохион байгуулах	Тоо: Гадаад арга хэмжээний тоо -Хамтран ажиллах удирдамж хөтөлбөрийг батлуулсан эсэх Санамж бичиг гэрээ хэлэлцээрийн тоо Хамтран ажиллах гэрээг хянуулж, зөвшөөрөл авсан эсэх Чанар: Гадаад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах Хугацаа: Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ажлын 7 хоногт багтаан тухай бүр танилцуулж тайлагнах	Сум орон нутагт гадаад бодлого хамтын ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан байна.
13	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг сум орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх	Тоо: Тухай суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн тоо Чанар: Төсөл хөтөлбөрийг хариуцлагатай, хамтын уялдаа холбоотой үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Төсөл хөтөлбөрийн үр өгөөж нэмэгдсэн байна.
Гамшгийн үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд			
14	Аймгийн Онцгой комиссоос өгссөн үүрэг даалгаврыг тухай бүр сум орон нутагт шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах	Тоо: Зохион байгуулсан ажил арга хэмжээ Чанар: Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж ажиллах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сум орон нутагт цаг үеийн арга хэмжээг шуурхай, үр дүнтэй зохион байгуулсан байна.
15	Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж шуурхай штабын байгуулж, албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх	Чанар: Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Шуурхай штабын бэлэн байдал хангагдсан байна
16	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хагас бүтэн жилээр тодотгол хийж,	Тоо: 2 удаа Чанар: Гамшгаас хамгаалах мэдээлэл	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний

1	2	3	4
	хэрэгжилтийг хангах	шинэчлэгдсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	мэдээлэл шинэчлэгдсэн байна
17	Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцасны нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлэх	Тоо: Тухай бүр Чанар: Хамгаалах хэрэгслийн нөөцийг 20 хувиар нэмэгдүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна
18	Гамшгаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлэх	Тоо: Тухай бүр Чанар: Нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Гамшгийн нөөц хөрөнгийг бүрдүүлсэн байна
19	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, хорио цээрээр хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажиллах, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	Тоо: Тухай бүр Хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажиллах Соён гэгээрүүлэх ажлыг 4 удаа зохион байгуулах Чанар: Хорио цээрээр хязгаарлалтыг тогтоох, Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажилласан байна. Иргэд малчдын, хүн мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилсэн байна
20	Гамшиг осол, аюулт үзэгдэл гал түймэр, хүн мал амьтны гоц халдварт өвчний үед ажиллах гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах	Тоо: Тухай бүр Чанар: Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үүрэг оролцоог сайжруулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал хангагдсан байна
Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:			
21	Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийн дагуу аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх 2023 оны арга хэмжээний болон Авлигын эсрэг соён гэгээрүүлэх аймгийн 2023 оны нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг орон нутагтаа зохион байгуулж, биелэлтийг тооцон ажиллах.	Тоо: Тус бүр 10-аас доошгүй арга хэмжээ Чанар: "Иргэний эрх"-ийг зөрчсөн зөрчил, авлига, албан тушаалын гэмт хэрэг бүртгэгдээгүй байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, иргэд, төрийн албан хаагчдыг мэдээллээр хангаж соён гэгээрүүлсэн байна.
22	Орон нутгийн хэмжээнд Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах.	Тоо: Байнга Чанар: Захиргааны акт зөрчлийн тоо Захиргааны гэрээг хяналтад авах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангагдаж, хүний эрхийн зөрчил гараагүй байна.

1	2	3	4
23	Мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шинээр батлагдах хууль тогтоомжийн төсөлд санал авах хэлэлцүүлэг сургалт зохион байгуулах ажлыг орон нутагт хэрэгжүүлэх	Тоо: 10-аас доошгүй удаа 1000-аас доошгүй иргэнд, 5-аас удаагийн сургалт хийх Чанар: Хэлэлцүүлгээс гарсан саналын хэрэгжүүлсэн эсэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол, ухамсар дээшилж, сумын хэмжээнд өмнөх онуудад гарсан нийт гэмт хэрэг, зөрчлийн тоо өмнөх оноос буурсан байна.
24	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх Эрх зүйн ажилд тодорхой хөрөнгө төсөвлөн зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн эрх зүйн албан бус сургалтыг хийж, хууль тогтоомж, бүх шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг төрөл бүрийн арга хэрэгслээр хүртээмжтэй, үр дүнтэйгээр сурталчлах ажлыг зохион байгуулах	Тоо: 10-аас доошгүй арга хэмжээ Чанар: Бодитой үр дүнтэй, туршлага болохуйц ажил арга хэмжээ зохион байгуулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.
25	Хууль тогтоомжоор тогтоосон сумын Засаг даргын эрх хэмжээний асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, сумын Хэсгийн төлөөлөгчтэй гуравласан гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр биелэлтийг тооцож ажиллах	Тоо: байнга Чанар Гэмт хэргийн тоо, буурч, илрүүлэлт өссөн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сумын хэмжээнд өсөлттэй гэмт хэргүүд буурсан байна.
26	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, хэрэгжүүлэн ажиллах	Тоо: Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Чанар: Хэрэглэгчийн мэдлэг дээшилсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сумын нийт хэрэглэгчдийн эрх ашиг хангагдаж гомдол, зөрчил бүртгэгдээгүй байна.
27	Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Сумын хэмжээнд тооны гарын үсгийг бүрэн нэвтрүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
28	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Урьдчилан сэргийлэх бодитой ажил арга хэмжээ зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.
29	Сумын нийт гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулж ажиллах	Тоо: Урьдчилан сэргийлэх 3-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байх Чанар: Гэмт хэрэг, зөрчлийн тоо 0.5 хувиар	Нийт гэмт хэрэг, зөрчлийг тоо өмнөх оноос буурсан байна.

1	2	3	4
		буурсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	
30	"Зөв-Амьдрал" аймгийн дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллах	Тоо: Урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2-3 удаа зохион байгуулах Чанар: Согтуугаар үйлдэх гэмт хэргийн тоо буурах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Согтуугаар үйлдэх гэм хэргийн тоог өмнөх оноос 0,5 хувиар бууруулсан байна.
31	Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг архины эмчилгээнд хамруулж, ажлын байраар хангах	1-3 Иргэнийг архинаас гаргаж, ажлын байраар хангасан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Архины хамааралтай иргэд архинаас гарч, ажлын байраар хангагдаж, өрхийн орлого нэмэгдсэн байна.
32	"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх"	Тоо: Тус бүр 5-аас доошгүй арга хэмжээ Чанар: Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Гэмт хэрэг, зөрчлийн тоо өмнөх оноос буурсан байна
33	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хуулийг сурталчилсан ажилласан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.
34	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах	Тоо: баримтын тоогоор Чанар: -Баримтыг цаг тухай бүрд нь бүрэн баримтжуулах, бүрдүүлж, баталгаажуулах -Баримтын хуулийн хүчинтэй байдал, стандарт, шаардлагыг хангасан байх -Баримтыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх -Байгууллагын архивд 2022 оны баримтыг бүрэн хүлээн авсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.
35	Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт ажилтнууд 16 цагийн сургалтад хамрагдах	Тоо: 3000 Чанар: Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Төрийн албан хаагчдын сургалтад 100 хувь бүрэн хамруулж мэдлэг, ур чадвар дээшлүүлсэн байна.

1	2	3	4
36	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, "Цахим архив-Баянхонгор" дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2020 оны байнга хадгалах баримтыг цаасаар болон цахим хувь, дансны хамт шилжүүлэх	Тоо: Байгууллагын архивын баримтыг Төрийн архивд бүрэн бүрдлээр хүлээлгэн өгсөн байх Чанар: Хүлээлгэн өгсөн баримтыг чанар, байгууллагын ББНШ комисс шалгасан эсэх Хугацаа: 2023 оны 4 дүгээр сард тайлагнах	Байгууллагын баримтыг бүрэн, бүрдэлтэй шилжүүлсэн байна.
37	"Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	Тоо: Архивын өрөө тасалгааг тохижуулах, нягтруулсан тавиур шүүгээ, дохиолол, дагалдах хэрэгслээр хангах Чанар: байгууллагын архивын хадгалалт хамгаалалт сайжруулах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Байгууллага бүр архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна.
38	Байгууллагын тусгай төрлийн /гэрэл зураг, дуу дүрсний/ 2023 оны баримтыг Төрийн архивд шилжүүлэх	Тоо: Сум, байгууллагын 2023 оны баримтыг хүлээлгэн өгсөн байх Чанар: 100 хувь хүлээлгэн өгсөн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Баримтыг Төрийн архивд шилжүүлсэн байна.
Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг сайжруулах хүрээнд:			
39	Орон нутагт боловсролын тулгамдаж буй асуудлыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн, гарсан санал санаачлагыг бүрэн хэрэгжүүлэх	Тоо: 2-оос доошгүй удаа хэлэлцүүлэх Чанар: Боловсролын үйлчилгээний чанарт ахиц гарсан байх Хугацаа: Нийгмийн бодлогын хэлтэст хагас бүтэн жилээр тайлагнах	Тулгамдсан асуудал шийдвэрлэсэн байна.
40	Таван настнуудыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах, малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих	Тоо: 5 настай хүүхдийн тоо Чанар: Сургуулийн өмнөх боловсролыг бүрэн эзэмшүүлж, сургуульд бэлтгэгдсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Таван настнуудыг бүрэн хамруулж, сургуулийн өмнөх боловсрол олгож, сургуульд бэлтгэсэн байна
41	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчны эрсдэлийн үнэлгээг хийж, хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт	Тоо: 3 стандартыг хангах Чанар: MNS6782:2019, MNS6558:2015, MNS 6781 :2019 стандартын шаардлагад нийцүүлсэн байх Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулж,	Хүүхэд хамгааллыг сайжруулсан байна.

1	2	3	4
	нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах.	урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	
42	Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, төрийн албан хаагчдын болон иргэдийн "Монгол бичиг"-ийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх	Тоо: Төрийн албан хаагчдын тоо Иргэдийн тоо Чанар: Төрийн албан хаагчдын 90 –дээш хувийг "Монгол бичиг"-ийн анхан, дунд, ахисан түвшний сургалтад хамруулсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Төрийн албан хаагчдын монгол бичгийн ур чадвар дээшилж, төрийн албыг монгол бичгээр хослон эрхлэх бэлтгэлийг хангасан байна
43	Цэцэрлэг, сургуулийн сурагчдын эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын бодисын хангамжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих	Тоо: Стандартын дагуу ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийсэн байх Иргэд, аж ахуй нэгжийн хандив тусламжийн хэмжээ Чанар: Орчны ариун цэвэр халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийсэн байх Ариутгалын бодисын хангамжийг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сургууль цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт сайжирч халдвар өвчний гаралт буурсан байна. Иргэд, аж ахуй нэгжээс ирсэн хандивын хэмжээ Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, багаж хэрэгслийн хангамж нэмэгдсэн байна
44	Багш, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах	Тоо: Багш, ажилтан, суралцагчдын 80-аас доошгүй хувийг хамруулах Нийгмийн баталгааг хангахад зарцуулсан төсвийн хэмжээ /тусламж/ Чанар: Багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Багш нарын нийгмийн баталгааг хангахад ахиц гарсан байна.
45	Багш, нарын мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, "Багш хөгжлийн төв" -д дэмжлэг үзүүлэх;	Тоо: Чадваржуулсан багш, удирдах ажилтны тоо Чанар: Багш ажилтны цахим ур чадварыг дээшлүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	"Багш хөгжлийн төв" – ийн үйл ажиллагаа өргөжиж багш удирдах ажилтны ажлын байран дээрх мэргэжил, ур чадвар сайжирсан байна

1	2	3	4
46	Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Тоо: 2-11 дүгээр ангийн сурагчдын тоо Чанар: Хоцрогдлыг 15-аас дээш хувиар бууруулах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хүүхдийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бага суурь боловсролын стандартыг хангасан байна.
47	Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, тохирлын баталгаанд хамруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах	Тоо: Эрхэлж буй туслах аж ахуйн тоо Чанар: Төмс хүнсний ногоо тарих, мал, тахиа, гахайн аж ахуй эрхлэх, -Сум орон нутагт үйл хоол хүнсний чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгжтэй хамтран ажиллах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сургуулийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ахиц гарч, хүнсний аюулгүй байдал хангагдсан байна.
48	Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээг үргэлжлэн салбарын дунд уялдааг сайжруулах, бичиг үсэг үл мэдэгч залуучуудыг бичиг үсэгт тайлах, иргэдийн болон төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх	Тоо: Өрхийн тоо хөдөөгийн сум баг тус бүрээс 2 өрх, Баянхонгор сумд баг бүрээс 5 өрх хамрагдсан байх Бичиг үсэг тайлах сургалтад хамрагдсан иргэдийн тоо Үндэсний бичгийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Иргэдийн амьдрах чадвар, бичиг үсгийн болон үндэсний бичгийг мэдлэг чадварын түвшин дээшилсэн байна.
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн хүрээнд:			
49	Иргэн бүрийг хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	Тоо: Хамрагдсан иргэдийн тоо Чанар: Эрүүл мэндийн үйлчилгээний чанаржсан байх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Сумын нийт хүн амын 60-аас дээш хувийг хамруулж, эрүүл мэндийн салбарын чанар хүртээмж сайжирсан байна.
50	Сургууль цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар хүртээмжийг сайжруулан ("үдийн хоол", "эрүүл шүд") хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангах	Тоо: Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хүүхдийн тоо Чанар: Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалсан байна
51	Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай	Чанар: Эндэгдлийг бууруулсан хувь Хугацаа: Хагас бүтэн	Өмнөх оноос 0.5 хувиар буурсан байна.

1	2	3	4
	бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах	жилээр тайлагнах	
52	“Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнийг сум орон нутагтаа өрнүүлэх, архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, Монгол хүнийг өвчлөхөөс урьтаж урьдчилан сэргийлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Тоо: Архи, тамхи хорт зуршлын хэрэглээнээс татгалзсан иргэдийн тоо Чанар: Иргэдэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь 90 түүнээс дээш байна.
53	Сумдын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмч эмнэлгийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагын зөрчлийг бууруулах	Тоо: Тусламж үйлчилгээ, ёс зүй, харилцаа хандлагын алдаа дутагдлын батлагдсан тохиолдлын тоо Чанар: Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг өмнөх оноос сайжруулсан байна.
54	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, халдварт өвчний гаралтыг бууруулах	Тоо: Халдварт өвчний тохиолдлын тоо Чанар: Халдварт өвчнийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байх Хугацаа: Хагас бүтэн жилээр	Халдварт өвчнийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80 түүнээс дээш хувьтай байна.
55	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Тоо: Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо Хувь: Хамралтын хувь Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.
Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:			
56	Ажилгүй иргэдийн судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлж, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах	Тоо: Ажилгүй иргэдийн тоо Байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо Чанар: Ажлын байрыг тогтвортой хадгалах нөхцөлийг бүрүүлэх Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	Байнгын ажлын байраар 20-25, түр ажлын байраар 150-250 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулсан байна.
57	Алслагдсан багт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн, тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн боловсрол,	Тоо: Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд оролцуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,	Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 30-аас доошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний 60-аас доошгүй

1	2	3	4
	хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх, сургалт, нөлөөллийн ажил, хэлэлцүүлэгт хамруулж, саналыг нь сонсох замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах	иргэдийн тоо Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах	хувийг хамруулж, нийгмийн оролцоог 5 хувиар нэмэгдүүлсэн байна.
58	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Ахмадын шийдвэрлүүлэн, Ахмадын өргөөг өдөр тутмын идэвхтэй үйл ажиллагаатай байлгаж ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллах	Тоо: Ахмадын өргөө, танхимаар үйлчлүүлсэн иргэдийн тоо Үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тайлагнах	Ахмадын өргөө, танхимыг орон нутгийн нөөцөд тулгуурлан байгуулж, дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулсан байна.
59	“Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж, нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжид тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Тоо: Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо Хугацаа: Хагас, бүтэн жилээр тайлагнах	Байгууллага, аж ахуйн нэгжийн 50-иас доошгүй хувь Ахмадын сан байгуулж, Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.
